



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/333

Мөрөн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.7, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 69/A2260435 дугаартай албан шаардлагаар Мөрөн сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй "Мөрөн сумын Жилчиг 10 дугаар багийн нутаг дэвсгэрт 6712015632 нэгж талбарын дугаартай, 2800 м² газрыг 58 өрхөд амины орон сууцны зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэх"-ээр шийдвэрлэсэн нь газрын тухай хууль тогтоомжийг зөрчсөн болох нь тогтоогдсон тул Мөрөн сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/213 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2. Дээрх захирамжийн хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийн бүртгэлийг Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сангаас хасалт хийж, захирамжийг холбогдох этгээдэд танилцуулах ажлыг шуурхай зохион байгуулж, баримтыг бүрдүүлэн ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийг эс зөвшөөрвөл захирамж гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Мөн энэхүү захирамж гарсантай холбогдуулан Мөрөн сумын Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/31 дүгээр захирамжийг хүчингүй хэвээр үлдээсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН